



## НИЙСЛЭЛИЙН АГЕНТЛАГУУДАД ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зөвлөн туслах үйлчилгээний зорилго

Нийслэлийн агентлагуудын үйл ажиллагаатай танилцаж, тэдгээрт хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх, мэргэжлийн туслалцаа үзүүлэх замаар эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад чиглэгдэнэ.

Хоёр. Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх хууль, эрх зүйн үндэслэл

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2017 оны нэгдсэн төлөвлөгөөний дагуу Нийслэлийн агентлагуудад Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай, Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох тухай хууль, Засгийн Газрын 1991 оны 13 дугаар тогтоолын хавсралт “Ажилласан хугацааг тооцох журам”, 1994 оны 212 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам” болон бусад тушаал, шийдвэрийн хэрэгжилтэнд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/138 дугаар тушаалаар баталсан “Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх заавар”-ыг баримтлан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.

Гурав. Зөвлөн туслах үйлчилгээний төрөл, арга хэлбэр

Төлөвлөгөөт, хамтарсан зөвлөн туслах үйлчилгээ.

Зөвлөн туслах үйлчилгээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр тухайн байгууллагын даргын хүний нөөцтэй холбоотой гаргасан тушаал, шийдвэр, ажиллагсдын хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтэрт тулгуурлан явуулна.

Дөрөв. Зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдах объект

Мэргэжлийн хяналтын байгууллагын 2017 оны хяналт шалгалтын ажлын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдаж, зарлагдсан аж ахуйн нэгж, байгууллагууд хамрагдана.

Тав. Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх бүрэлдэхүүн, хугацаа

Нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч З.Болормаа ахалж, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчид, 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 09 дүгээр сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Зөвлөх үйлчилгээний хүрээнд хийх ажил, ашиглах хяналтын хуудас

6.1 Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагуудын ажилтан, албан хаагчдад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх ба 4.2 кодтой "Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас", 4.6 кодтой "Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудас"-аар үнэлж, хавсралт хүснэгт дэх асуудлаар хүн бүрийн ажилласан жилийн хугацааг тооцож гаргана.

6.2 Ажилласан жилийн үзлэгээр эрсдэлийн түвшинг үнэлж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар эрх зүйн болон мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллана.

6.3 Зөвлөн туслах үйлчилгээний явцад үзлэгийн дүнгээр зөвлөмжийг бичгээр гаргаж, объектод ажилласнаас хойш ажлын 5 өдөрт багтаан хүргүүлнэ.

6.4 Зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх явцад хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хор хохирол учруулсан, учруулж болзошгүй ноцтой зөрчил илэрвэл төлөвлөгөөт бус шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн заалтын дагуу гүйцэтгэнэ.

6.5 Зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр сургалт зохион байгуулж болно.

Долоо. Зөвлөн туслах үйлчилгээг дүгнэх, үр дүнг хэлэлцэх

7.1 Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн улсын /ахлах/ байцаагчид объектын мэдээ тайланг хавсралт хүснэгтээр, авсан арга хэмжээ, түүний үр дүнгийн талаарх танилцуулгыг 2017 оны 09 дүгээр сарын 20-ны дотор Нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч З.Болормаад файлаар /d\_zuzbolor@yahoo.com/ болон бичгээр ирүүлнэ.

7.2 Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхэд ашигласан хяналтын хуудсын мэдээллийг тухай бүр цахим системд оруулна.

7.3. Зөвлөн туслах үйлчилгээний хөтөлбөрийн дүнг нэгтгэн, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын удирдлагууд, хэлтсийн даргад танилцуулж, МХЕГ-ын ХНХТХГ-т албан бичгээр хүргүүлнэ.

ТАНИЛЦСАН:

ХӨДӨЛМӨР,НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ТУСГАЙ ХЯНАЛТЫН ХЭЛТӨЙН  
ДАРГА

И.БАТТӨГС

БОЛОВСРУУЛСАН:

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

З.БОЛОРМАА

НИЙСЛЭЛИЙН ..... ГАЗРЫН АЖИЛЛАГСДЫН АЖИЛЛАСАН ЖИЛИЙН СУДАЛГАА

д/д	Овог нэр	Регистр №	хэлтэс	Албан тушаал	Ажилласан жил, сар						Тодорхойлсон огноо	Тайлбар	
					Төрийн албанд	Цэргийн алба	Хувийн хэвшилд	Сайн дурын даатгалд	нөхөн даатгал				Нийт
									1990-1995 /төр/	1995-2000			

СУДАЛГАА ГАРГАСАН:

УЛСЫН /АХЛАХ/ БАЙЦААГЧ

.....

2017 онд нийслэлийн агентлагуудад  
зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх хуваарь

№	Нийслэлийн агентлагуудын нэрс	Байцаагчийн нэр
1	Нийслэлийн улсын бүртгэлийн газар	Д.Бямбасүрэн
2	Нийслэлийн онцгой байдлын газар	Д.Бямбасүрэн
3	Нийслэлийн газрын алба	Д.Бямбасүрэн
4	Нийслэлийн авто замын газар	Д.Бямбасүрэн
5	Нийслэлийн дотоод аудитын алба	Ц.Бадмаа
6	Нийслэлийн мал эмнэлгийн газар	Ц.Бадмаа
7	Нийслэлийн мэдээлэл технологийн газар	Ц.Бадмаа
8	Нийслэлийн халамжийн газар	Ц.Бадмаа
9	Нийслэлийн өмчийн харилцааны газар	Ш.Хонгорзул
10	Нийслэлийн соёл урлагийн газар	Ш.Хонгорзул
11	Нийслэлийн статистикийн газар	Ш.Хонгорзул
12	Нийслэлийн татварын газар	Ш.Хонгорзул
13	Нийслэлийн эрүүл мэндийн газар	З.Болормаа
14	Нийслэлийн боловсролын газар	З.Болормаа
15	Нийслэлийн биеийн тамир, спортын газар	З.Болормаа

АЖИЛЛАСАН ЖИЛ ТООЦОХ ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЯВЦАД ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН ДҮН

Д/д	овог нэр	ажлын газар албан тушаал	нийт	төрд	зөрчлүүд																	
					ндш төлөгүй	тушаалын	тэмдэглэггүй	хүүхдээ асарсан	хугацааны ндш төлөгүй	ндш төлөгт баталгаажуулаагүй	2016онд амарсан хоног	аж жил, үзлэгийн дүнгийн зөрүү	зөрүүл тооцооны хэлбэрт	нийт дэвтэр	үүнээс хөд дэвтэр							

ДҮН НЭГТГЭСЭН:

УЛСЫН /АХЛАХ/ БАЙЦААГЧ

.....